*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт*

| **2022 оны жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/** | |
|---|---|
| Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй. | |
| Тайлагнах хугацаа | 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар | “Тавантолгой” ХК<br>Регистрийн дугаар: 2016656<br>Улсын бүртгэлийн дугаар: 1110001005<br>Үнэт цаасны код: TTL<br>Утас: 7535-5555, 9500-1619 |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар | Уул уурхай, Нүүрс олборлолт |
| Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар<br>Тайлан гаргасан огноо: 2023.04.01 |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг | 52,665,200 ширхэг |
| Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр | Бэлтгэсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Төрмандах, Захиргаа удирдлагын газрын захирал Б.Мөнгөнсүх<br>Хянасан: Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч П.Сайнзориг |

| | |
|---|---|
| 1 | Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ |

| | | |
|---|---|---|
| | Санхүүгийн байдлын үзүүлэлт | 2022 онд нийт хөрөнгийн дүн 456,714.8 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 96.4 хувь буюу 440,130.7 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 3.6 хувь буюу 16,584.2 сая төгрөгийг эзэлж байна. Нийт эх үүсвэр 456,714.9 сая төгрөг , үүнээс өр төлбөр 132,942.7 сая төгрөг, эзний өмч 323,772.13 сая төгрөг байна.<br>2022 оны санхүүгийн тайлан хавсаргав. |
| | Орлогын тайлан | 2022 онд 762,406.9 сая төгрөгийн орлоготой, 358,662.8 сая төгрөгийн зардалтай, 331,005.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. |
| | Өмчийн өөрчлөлтийн тайлан | 2022 онд 331,005.1сая төгрөгийн ашигтай ажиллаж оны эцэст эзний өмчийн дүн 323,772.13 сая төгрөг байна. |
| | Мөнгөн гүйлгээний тайлан | 2022 онд бүх цэвэр мөнгөн гүйлгээ 770,466.91 сая төгрөг, оны эцсийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 408,542.7 сая төгрөг байна. |
| 1.1 | Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт | |
| | Хөндлөнгийн Аудитийн байгууллагаас “Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайлан тэнцэлд дараах дүгнэлтийг ирүүлсэн:<br>Товч утга: Аудитын дүгнэлт гаргах хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг мөрдөн шалгах ажиллагаа явуулж санхүүгийн бүх баримт материалыг татан авсан тул аудитад шаардлагатай цаасан болон цахим хэлбэрийн баримт материалаар хангагдаагүй нь санхүүгийн тайлан дахь дүн мэдээллийг нотлох, аудит хийх боломжгүй нөхцөл байдал үүсгэсэн тул зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй гэж үзсэн.<br>Аудитын дүгнэлт хавсаргав. | |

| | | |
|---|---|---|
| 1.2 | Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/ | |
| | Дүгнэлт өгөхөөс татгалзсан. | |
| 2 | Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл | |
| 2.1 | Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/ | Тус компани тайлант онд нийт 762,406.9 сая төгрөгийн орлоготой, 358,662.8 сая төгрөгийн зардалтай, 331,005.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. |
| 2.2 | Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт | Эргэлтийн харьцаа 3.31<br>Шуурхай төлбөрийн харьцаа 3.27 |
| 2.3 | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл | Компанийн үндсэн үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлэх, нүүрсний гадаад зах зээлийн таатай нөхцөл байдлыг ашиглах, цар тахлын нөлөөнөөс гарч, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан. Түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалж хөрс хуулалтын зардал өссөн, бараа бүтээгдэхүүний хомсдолоос шалтгаалж хөрс хуулалтын ажилд зогсолт саатал гарч, хөрс хуулалт төлөвлөсөн хэмжээнээс бага гарсан.<br><br>Нүүрсний үнийг гадаад зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан оновчтой зохион байгуулж ажилласан. Гадаад вальютын ханшийн өсөлт нь борлуулалтын орлогод шууд нөлөөлсөн. |
| 2.4 | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх | “Тавантолгой” ХК нь 2022 онд Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн |

| | | |
|---|---|---|
| | дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/ | ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НБББBичгийн дагуу бүртгэсэн. |
| 2.5 | Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл; | “Тавантолгой” ХК нь эргэлтийн хөрөнгөөр санхүүжиж ямар нэгэн зээл аваагүй ажилласан. |
| 3 | Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ | |
| | Тайлант хугацаанд сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй. | |
| 4 | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл | |
| | ➢ “Тавантолгой” ХК нь компанийн засаглалын бүтцийн хувьд дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:<br>- Хувьцаа эзэмшигчдийн хурал,<br>- Төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга,<br>- Гүйцэтгэх захирал, Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч<br>- Газрын захирал,<br>- Хэлтсийн захирал,<br>- Албаны дарга,<br>➢ Тайлант хугацаанд компанийн удирдлагын хүрээнд дараах үйл ажиллагаа явагдсан. Үүнд:<br>• Хувьцаа эзэмшигчдийн хурал: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 14 цагаас компанийн төв байранд зохион байгуулсан. Хуралтай холбоотой мэдээллийг холбогдох журмын дагуу олон нийтэд мэдээллэх, холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэн ажилласан.<br>• ТУЗ-ийн гишүүд: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллаж байсан 9 гишүүн (хараат бус 3 гишүүн, ердийн 6 гишүүн) дахин сонгосон. | |

| | |
|---|---|
| | • <u>ТУЗ-ийн дэргэдэх хороод:</u> Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулан ажиллаж байна.<br>• <u>ТУЗ-ийн хурал:</u> Үйл ажиллагааны журамд заасны дагуу хурлын үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд 15 удаагийн танхимын болон эчнээ санал хураалтаар 37 тогтоол гарган ажилласан. |
| 5 | Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл |
| | Нүүрс борлуулалтын хувьд 100% гадаад зах зээлээс хамааралтай байгаа бөгөөд нүүрс тээвэрлэлт, хилийн нөхцөл байдал тогтворгүй, салбарын бодлого шийдвэр тодорхойгүй, эрсдэлтэй. |
| 6 | Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/ |
| | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар татан авсан Үнэт цаас эзэмшигчдийн судалгаагаар компани нийт 2,682 хувьцаа эзэмшигчтэй байсан.<br><br>2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар 5 болон түүнээс дээш хувь эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид:<br><br>1. Орон нутгийн өмч – 51%<br><br>2. Ажнай корпораци ХХК – 19.78%<br><br>3. Шандас Импекс ХХК – 16.31% |
| 7 | Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл |
| | Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор хувьцаа нэмж гаргаагүй. |
| 8 | Ногдол ашгийн мэдээлэл |
| | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 43 дугаартай тогтоолоор 2021 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд 98.1%-иар буюу нэгж хувьцаанд 257 төгрөг хуваарилан олгох, ногдол ашиг олгох өдрийг 2022 оны 04 дүгээр |

сарын 29-ны өдөр байхаар шийдвэрийг гаргасан. Шийдвэрийн дагуу ногдол ашгийг Компани болон Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 100% хуваарилж ажилласан.

9

Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл:

## 2022 ОН НҮҮРСНИЙ САЛБАРТ







## 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Нүүрс борлуулалт
**2.80** сая тонн

Борлуулалтын орлого
**762.4** тэрбум төгрөг

Экспортын борлуулалт
**2.66** сая тонн

Цэвэр ашиг
**331.0** тэрбум төгрөг

Хөрс хуулалт
**10.7** сая метр куб

Төсөвт төлсөн татвар
**283.9** тэрбум төгрөг

## ӨНГӨРСӨН ОНУУДТАЙ ХАРЬЦУУЛАХАД













## 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ, БИЕЛЭЛТ













| | |
|---|---|
| 10 | Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл |

| | |
|---|---|
| | • “Тавантолгой” ХК нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж 7.5 сая мод тарих амлалт авсан бөгөөд аймаг орон нутгийн зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалахад 1,5 сая мод тарихаар болсон. Энэ мод тарихтай холбоотойгоор Өмнөговь аймгийнхаа хэмжээнд Булган, Номгон, Даланзадгад, Цогтцэций сумдад 1- 2,5 сая мод тарих төлөвлөгөөг хийж байна. 2022 онд Даланзадгад суманд 3 га талбайд мод үржүүлгийн газар байгуулсан бөгөөд тухайн талбайдаа 6 төрлийн модыг үр болон мөчрөөр үржүүлж 1,8 сая орчим тарьц ургуулаад байна.<br>• Жил бүр уламжлал болгон зарладаг оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг зарлан шалгаруулж 55 хүүхдэд оюутны тэтгэлэг олгон батламж гардуулсан. |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: П.Сайнзориг

Албан тушаал: “Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч

Гарын үсэг: ……………………………………….

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Мөнгөнсүх

Албан тушаал: “Тавантолгой” ХК Захиргаа, удирдлагын газрын захирал

Гарын үсэг: ……………………………………….

Овог, нэр: Ч.Төрмандах

Албан тушаал: “Тавантолгой” ХК Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ……………………………………….

ТАВАНТОЛГОЙ ХК

# 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,

# Аудитын албан бичиг

/Сангийн яаманд баталгаажуулахаар илгээсэн/

**Байгууллагын нэр: Тавантолгой**
**Регистр: 2016656**

## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | 0.0 | 0.0 |
| 1.1 | **Эргэлтийн хөрөнгө** | 0.0 | 0.0 |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 81,489,047.1 | 408,542,723.6 |
| 1.1.2 | Дансны авлага | 15,579,051.0 | 25,020,602.8 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 177,578.1 | 162,990.4 |
| 1.1.4 | Бусад авлага | 99,887.4 | 90,453.4 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 0.0 | 0.0 |
| 1.1.6 | Бараа материал | 37,471,813.3 | 5,313,772.4 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 2,247,122.9 | 976,920.4 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 25,980.0 | 23,220.0 |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 1,053,686.4 | 0.0 |
| 1.1.10 | | 0.0 | 0.0 |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | 138,144,166.2 | 440,130,683.0 |
| 1.2 | **Эргэлтийн бус хөрөнгө** | 0.0 | 0.0 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 14,781,291.3 | 15,030,366.8 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 1,339,443.7 | 1,119,666.2 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | 0.0 | 0.0 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 434,179.5 | 434,179.5 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | 0.0 | 0.0 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 0.0 | 0.0 |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 0.0 | 0.0 |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 0.0 | 0.0 |
| 1.2.9 | | 0.0 | 0.0 |
| 1.2.10 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | 16,554,914.5 | 16,584,212.5 |
| 1.3 | **Нийт хөрөнгийн дүн** | 154,699,080.7 | 456,714,895.5 |
| 2 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | 0.0 | 0.0 |
| 2.1 | **ӨР ТӨЛБӨР** | 0.0 | 0.0 |
| 2.1.1 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.0 | 0.0 |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 10,729,626.7 | 2,531,042.1 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 197,358.7 | 721,579.4 |
| 2.1.1.3 | Татварын өр | 49,901,308.9 | 84,540,585.3 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 26,448.9 | 0.0 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 0.0 | 0.0 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 0.0 | 0.0 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | 658,515.4 | 658,515.4 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 32,853,524.4 | 44,489,929.3 |
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | 0.0 | 0.0 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 991.4 | 1,114.2 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр | 0.0 | 0.0 |
| 2.1.1.12 | | 0.0 | 0.0 |
| 2.1.1.13 | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | 94,367,774.4 | 132,942,765.7 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.1.2 | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.0 | 0.0 |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 0.0 | 0.0 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | 0.0 | 0.0 |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 0.0 | 0.0 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 0.0 | 0.0 |
| 2.1.2.5 | | 0.0 | 0.0 |
| 2.1.2.6 | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | 0.0 | 0.0 |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | 94,367,774.4 | 132,942,765.7 |
| | **ЭЗДИЙН ӨМЧ** | 0.0 | 0.0 |
| 2.3 | **Өмч** | 94,487.6 | 94,487.6 |
| 2.3.1 | -төрийн | 48,188.7 | 48,188.7 |
| 2.3.2 | -хувийн | 46,298.9 | 46,298.9 |
| 2.3.3 | -хувьцаат | 0.0 | 0.0 |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | 0.0 | 0.0 |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 0.0 | 0.0 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 468,414.3 | 468,414.3 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 0.0 | 0.0 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 0.0 | 0.0 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 59,768,404.4 | 323,209,227.9 |
| 2.3.10 | | 0.0 | 0.0 |
| 2.3.11 | **Эздийн өмчийн дүн** | 60,331,306.3 | 323,772,129.8 |
| 2.4 | **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | 154,699,080.7 | 456,714,895.5 |

Захирал ........................ /П.Сайнзориг/

Нягтлан бодогч ........................ /null/

**Байгууллагын нэр: Тавантолгой**
**Регистр: 2016656**

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/Мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 179,329,481.8 | 762,406,943.9 |
| 2 | Борлуулалтын өртөг | 155,305,775.9 | 358,662,792.2 |
| 3 | **Нийт ашиг ( алдагдал)** | 24,023,705.9 | 403,744,151.7 |
| 4 | Түрээсийн орлого | 0.0 | 0.0 |
| 5 | Хүүний орлого | 838,130.1 | 762,375.6 |
| 6 | Ногдол ашгийн орлого | 0.0 | 0.0 |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | 0.0 | 0.0 |
| 8 | Бусад орлого | 258,793.4 | 225,789.8 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 0.0 | 0.0 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 3,787,585.4 | 4,839,881.8 |
| 11 | Санхүүгийн зардал | 0.0 | 0.0 |
| 12 | Бусад зардал | 2,389,189.8 | 3,534,689.4 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | -21,061.3 | 33,538,691.7 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | -100,789.7 | 0.0 |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.0 | 0.0 |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | 0.0 | 0.0 |
| 17 | Бусад ашиг ( алдагдал) | 0.0 | 0.0 |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | 18,822,003.2 | 429,896,437.6 |
| 19 | Орлогын татварын зардал | 3,756,659.6 | 98,891,332.0 |
| 20 | **Татварын дараахь ашиг (алдагдал)** | 15,065,343.6 | 331,005,105.6 |
| 21 | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | 0.0 | 0.0 |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | 15,065,343.6 | 331,005,105.6 |
| 23 | **Бусад дэлгэрэнгүй орлого** | 0.0 | 0.0 |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | 0.0 | 0.0 |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.0 | 0.0 |
| 23.3 | Бусад олз (гарз) | 0.0 | 0.0 |
| 24 | **Орлогын нийт дүн** | 15,065,343.6 | 331,005,105.6 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | 0.0 | 0.0 |

Захирал ....................... /П.Сайнзориг/

Нягтлан бодогч ....................... /null/

**Байгууллагын нэр: Тавантолгой**
**Регистр: 2016656**

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/Мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | 94,487.6 | 0.0 | 0.0 | 511,036.2 | 0.0 | 0.0 | 75,469,678.2 | 76,075,202.0 |
| 1 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 2 | **Залруулсан үлдэгдэл** | 94,487.6 | 0.0 | 0.0 | 511,036.2 | 0.0 | 0.0 | 75,469,678.2 | 76,075,202.0 |
| 3 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 15,065,343.6 | 15,065,343.6 |
| 4 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 5 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 468,414.3 | 0.0 | 0.0 | -2,590,735.4 | -2,122,321.1 |
| 6 | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 28,175,882.0 | 28,175,882.0 |
| 7 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.0 | 0.0 | 0.0 | -511,036.2 | 0.0 | 0.0 | 0.0 | -511,036.2 |
| 8 | **20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | 94,487.6 | 0.0 | 0.0 | 468,414.3 | 0.0 | 0.0 | 59,768,404.4 | 60,331,306.3 |
| 1 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | -54,015,533.3 | -54,015,533.3 |
| 2 | **Залруулсан үлдэгдэл** | 94,487.6 | 0.0 | 0.0 | 468,414.3 | 0.0 | 0.0 | 5,752,871.1 | 6,315,773.0 |
| 3 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 331,005,105.6 | 331,005,105.6 |
| 4 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 5 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 6 | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 13,548,748.8 | 13,548,748.8 |
| 7 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 8 | **20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | 94,487.6 | 0.0 | 0.0 | 468,414.3 | 0.0 | 0.0 | 323,209,227.9 | 323,772,129.8 |

Захирал ........................ /П.Сайнзориг/
Нягтлан бодогч ........................ /null/

**Байгууллагын нэр: Тавантолгой**
**Регистр: 2016656**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.0 | 0.0 |
| 1.1 | **Мөнгөн орлогын дүн** | 196,556,148.4 | 770,466,910.9 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 196,409,685.6 | 770,186,561.2 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 0.0 | 0.0 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 0.0 | 0.0 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 0.0 | 0.0 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 0.0 | 0.0 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 146,462.8 | 280,349.7 |
| 1.2 | **Мөнгөн зарлагын дүн** | 171,469,949.7 | 462,048,341.3 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 6,014,618.0 | 6,155,065.4 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,817,757.3 | 1,452,180.0 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 109,638,955.8 | 184,356,552.1 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 274,693.7 | 13,780.1 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 2,631,721.9 | 17,946.0 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 0.0 | 0.0 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 50,041,924.6 | 213,071,441.3 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 151,806.0 | 4,473.2 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 898,472.4 | 56,976,903.2 |
| 1.3 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | 25,086,198.7 | 308,418,569.6 |
| 2 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.0 | 0.0 |
| 2.1 | **Мөнгөн орлогын дүн** | 838,130.1 | 816,001.5 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 0.0 | 0.0 |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | 0.0 | 0.0 |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 0.0 | 0.0 |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | 0.0 | 0.0 |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 0.0 | 0.0 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 838,130.1 | 816,001.5 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | 0.0 | 0.0 |
| 2.1.8 | | 0.0 | 0.0 |
| 2.2 | **Мөнгөн зарлагын дүн** | 852,456.2 | 0.0 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 852,456.2 | 0.0 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.0 | 0.0 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 0.0 | 0.0 |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.0 | 0.0 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 0.0 | 0.0 |
| 2.2.6 | | 0.0 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | -14,326.1 | 816,001.5 |
| 3 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.0 | 0.0 |
| 3.1 | **Мөнгөн орлогын дүн** | 29,637.9 | 33,540,781.3 |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.0 | 0.0 |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.0 | 0.0 |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | 0.0 | 0.0 |
| 3.1.4 | | 29,637.9 | 33,540,781.3 |
| 3.2 | **Мөнгөн зарлагын дүн** | 39,558,138.1 | 15,721,675.9 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 0.0 | 0.0 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0.0 | 0.0 |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | 0.0 | 0.0 |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 39,507,496.2 | 12,921,675.9 |
| 3.2.5 | | 50,641.9 | 2,800,000.0 |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | -39,528,500.2 | 17,819,105.4 |
| 4 | Валютын ханшийн зөрүү | 0.0 | 0.0 |
| 4.1 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | -14,456,627.6 | 327,053,676.5 |
| 5 | **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | 95,945,674.7 | 81,489,047.1 |
| 6 | **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | 81,489,047.1 | 408,542,723.6 |

Захирал ........................ /П.Сайнзориг/

Нягтлан бодогч ........................ /null/

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 244

танай ______________-ны № ______________ -т

ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН
ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ
П.САЙНЗОРИГ ТАНАА

**Дүгнэлт өгөхөөс татгалзсан**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийхээр төлөвлөсөн.

Тавантолгой ХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн ба өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд дүгнэлт өгөх хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

**Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл**

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байна. Үүнд:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглаварт хугацаанд ирүүлсэн санхүүгийн байдлын тайланг 116,659.0 сая, орлогын дэлгэрэнгүй тайланг 75,548.2 сая, өмчийн өөрчлөлтийн тайланг 41,994.7 сая, мөнгөн гүйлгээний тайланг 4.5 сая төгрөгөөр тус тус өөрчлөн 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 197 дугаар албан бичгээр дахин ирүүлсэн.

Аудитын дүгнэлт гаргах хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг мөрдөн шалгах ажиллагаа явуулж санхүүгийн бүх баримт материалыг татан авсан тул аудитад шаардлагатай цаасан болон цахим хэлбэрийн баримт материалаар хангагдаагүй нь санхүүгийн тайлан дахь дүн мэдээллийг нотлох, аудит хийх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн.

Дээр дурдсан шалтгаан үр дүнд аудитын горим, сорил хэрэгжүүлж, санхүүгийн тайлангууд болон тодруулгууд нь зөв шударга бэлтгэж, толилуулсан гэх аудитын хангалттай зохистой нотолгоо олж авч чадаагүй, үүссэн тодорхой бус байдлуудын үр дагавар ба санхүүгийн тайланд үзүүлж болох нөлөөг тогтоох боломжгүй байгаа нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

016020343

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР